



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2025 оны 02 сарын 14 өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

Монголын ногоон намын дүрмийн
өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэхээс
татгалзах тухай

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Ганзориг даргалж, Танхимын тэргүүн Г.Алтанчимэг, Д.Мөнхтуяа, Ч.Хосбаяр, шүүгч Б.Амарбаясгалан, Г.Банзрагч, Д.Батбаатар, Н.Батзориг, М.Батсуурь, Х.Батсүрэн, Б.Батцэрэн, Н.Батчимэг, Н.Баярмаа, П.Золзаяа, М.Пүрэвсүрэн, П.Соёл-Эрдэнэ, С.Соёмбо-Эрдэнэ, Б.Цогт, Ц.Цогт, Д.Цолмон, Х.Эрдэнэсүвд нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанаар,

Монголын ногоон намын дүрмийн өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлэх тухай өргөдлийг шүүгч Ч.Хосбаярын илтгэснээр хэлэлцээд

ТОДОРХОЙЛОХ нь:

Монголын ногоон намын итгэмжлэгдсэн төлөөлөгч О.Батхүү 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр Улсын дээд шүүхэд өргөдөл гаргасан.

Уг өргөдөлд “Монголын ногоон нам нь Улс төрийн намын тухай хуульд нийцүүлэн дүрэмдээ өөрчлөлт оруулсан тул намын дүрмийг бүртгэж авахыг хүсье” гэжээ.

Дээрх өргөдөл, хавсралтаар ирүүлсэн баримтууд нь Улс төрийн намын тухай хууль болон Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2024 оны 06 дугаар тогтоолоор батлагдсан “Улс төрийн намын бүртгэл хөтлөх журам”-ын Хавсралт №5А-д заасан бүрдүүлбэрийн шаардлагыг хангасан эсэхийг шалгаж, журмын 6.6-д зааснаар Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцүүлэх санал гаргасны дагуу өргөдлийг хэлэлцэв.

ҮНДЭСЛЭХ нь:

Монголын ногоон намын дүрмийг шинэчлэн Улсын дээд шүүхэд бүртгүүлэхээр ирүүлсэн өргөдөл, түүнд хавсарган ирүүлсэн баримтуудыг Улс төрийн намын тухай хуулийн зохицуулалт, уг хуулиар шаардсан улс төрийн намын дүрмийн бүрдэл хэсэг, агуулгад нийцүүлэн нийт шүүгчийн хуралдаанаас хянаад дараах үндэслэлээр бүртгэхээс татгалзаж шийдвэрлэлээ.

1.Улс төрийн намын тухай хууль (2023 оны шинэчилсэн найруулга)-ийн 3 дугаар зүйлийн 3.1.2-т “намын гишүүнээс түдгэлзэх” гэж намын гишүүний эрхгүй, намын гишүүний, эсхүл намын дэмжигчийн хувиар намын үйл ажиллагаанд оролцохгүй байхыг ойлгоно”, 15 дугаар зүйлийн 15.2.3-т “намын гишүүнээр элсэх, намын гишүүнээс түдгэлзэх, намын гишүүний эрх, үүрэг, намын гишүүнээс хасах болон бусад сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл”-ийг намын дүрэмд тусгахаар заасан. Гэтэл тус намын дүрэмд намын гишүүнээс “түдгэлзэх үндэслэл”-ийг тодорхой нэрлэн заагаагүй байгаа нь хуулийн дээрх шаардлагыг хангахгүй байна.

Намын дүрмийн 3.5-ийн 1-д “намын гишүүн хуульд заасан үндэслэлээр гишүүнээс түдгэлзэж болох ...”, 3.6-д “Намын гишүүнд сахилгын шийтгэл ногдуулах, гишүүнээс хасах үндэслэл”, 3.6-ийн 1-д “Намын дүрэм, дотоод журам, ёс зүйн дүрмийг зөрчих, намын үйл ажиллагаанд саад учруулах үйлдэл гаргасан тохиолдолд сахилгын шийтгэл хүлээлгэх үндэслэл болно” гэж тусгасан нь ойлгомжгүй, ямар тохиолдолд намын гишүүнээс түдгэлзэх үр дагавар үүсэх талаар намын гишүүд урьдчилан мэдэх эрхийн хүрээнд тодорхой тохиолдлыг нэрлэн зааж, гишүүд хоорондоо хэлэлцсэний үндсэн дээр намын дүрмээ батлах шаардлагатай.

2.Улс төрийн намын тухай хууль (цаашид хуулийн гэх)-ийн 15 дугаар зүйлийн 15.2.4-т “намын удирдах дээд байгууллага, төлөөллийн төв байгууллага, гүйцэтгэх төв байгууллага, хяналтын байгууллага болон бусад байгууллага, тэдгээрийн бүрэлдэхүүн, бүрэн эрхийн хугацаа, эрх хэмжээ, хуралдуулах, шийдвэр гаргах журам;”-ыг тус тус намын дүрмээр зохицуулахаар заасан.

Намын дүрмийн 4.1.2-т “Их хурал хуралдуулах журам”, 4.1.2-ын 2-т “Их хурал хуралдах тов, төлөөлөгчдийн тоо, тэдгээрийг сонгох журмыг Бага хурал тогтооно.” гэж намын дүрэмд тусгасныг тодруулах шаардлагатай. Тухайлбал, Бага хурал нь Их хурлын бүрэлдэхүүний тоог тогтоох ажиллагааны дарааллыг намын дүрэмд тодорхой ойлгомжтой тусгах, мөн тус намын гүйцэтгэх төв байгууллага болох Удирдах зөвлөлийн бүрэн эрхийн хугацааг дүрэмд тусгаагүй байна.

3.Хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-д “намын даргыг сонгох, чөлөөлөх, огцруулах, түүний бүрэн эрхийн хугацаа, эрх хэмжээ”-г намын дүрмээр тусгайлан тогтоохоор заасан. Тус намын дүрмийн 5.4-ийн 1-д “намын дарга ёс зүйн ноцтой зөрчил гаргасан ...”, 2-т “хуульд заасан бусад үндэслэл.” гэж тусгасан нь ойлгомжгүй, ямар тохиолдолд намын даргыг чөлөөлөх, огцруулах талаар нэрлэн зааж, дүрэмдээ тусгах шаардлагатай.

4.Хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.8-д заасан “төрийн улс төрийн албан тушаалд болон намын удирдах албан тушаалд нэр дэвшигчийг сонгох, томилох, чөлөөлөх, тэдгээрт жендэрийн тэгш байдлыг хангах журам”-ыг намын дүрмээр зохицуулахаар заасан. Гэтэл дүрмийн Наймд “Намын удирдах албан тушаал, төрийн улс төрийн албан тушаал, бүх шатны сонгуульд нэр дэвшүүлэх, сонгох, томилох, чөлөөлөх” гэсэн атлаа хэрхэн чөлөөлөх талаар намын дүрэмд тусгаагүй орхигдуулсан.

5.Хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.9-д “намын хөрөнгө, орлогыг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам” гэж, 37 дугаар зүйлийн 37.7-д “Намын санхүүгийн тайланг хянан шалгах нэг, эсхүл түүнээс дээш тооны дотоод аудиторыг намын

төлөөллийн төв байгууллагаас дөрвөн жилийн хугацаатай томилно. Түүнийг нэг удаа улируулан томилж болно” 37.8-д “Намын санхүүгийн тайланг сонгуулийн төв байгууллагад хүргүүлэхээс өмнө намын гүйцэтгэх төв байгууллага хэлэлцэнэ” гэж тус тус заасан, үүний дагуу улс төрийн нам өөрийн дүрэмдээ санхүүгийн тайланг хянан шалгах дотоод аудиторын тоо, тэдгээрийг томилох журам, намын санхүүгийн тайланг намын гүйцэтгэх төв байгууллагаар хэлэлцүүлэх журам зэргийг тодорхой тусгах шаардлагатай.

6.Хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.2-т “намын төлөөллийн төв байгууллагын бүрэлдэхүүнийг дөрвөн жилээс илүүгүй хугацаагаар сонгох, эсхүл батламжлах, хяналтын байгууллагын бүрэлдэхүүнийг дөрвөн жилээс илүүгүй хугацаагаар сонгох, эдгээр байгууллагын тайланг дөрвөн жилийн хугацаанд нэгээс доошгүй удаа хэлэлцэх” гэж заасны дагуу эдгээр байгууллагуудын бүрэлдэхүүнийг сонгох болон тайланг хэлэлцэх хугацааг намын дүрэмд тодорхой заах шаардлагатай, тус намын дүрмийн 4.1.1-ийн 7-д “намын санхүүгийн тайлан болон үйл ажиллагааны тайланг хэлэлцэж батлах”-аар заасан хэдий ч эдгээр тайланг ямар хугацаанд хэдэн удаа хэлэлцэх талаар заагаагүй, хугацааг тодорхойлоогүй байна.

7.Хуулийн 20 дугаар зүйлийн 20.4-т “намын дүрмийг санаатай зөрчсөн, эсхүл намын үнэт зүйл, зарчмыг ноцтой зөрчсөнөөс бусад тохиолдолд намын гишүүнээс хасахыг хориглоно.” гэж заасан, Монголын ногоон намын дүрэмд намын гишүүний үүрэг, гишүүнчлэл түдгэлзүүлэх, гишүүнээс гарах, сахилгын шийтгэл ногдуулах, гишүүнээс хасах үндэслэлийг заасан боловч “санаатай зөрчил”, “ноцтой зөрчил”-ийг тодорхойлоогүй, ямар үйлдэл гаргасан тохиолдолд намын гишүүнийг ноцтой зөрчил гаргасан, санаатай зөрчил гэж үзэж, намын гишүүнээс хасах үр дагавар үүсэх талаар намын гишүүдээрээ хэлэлцэж дүрэмдээ тусгаж, гишүүдэд ойлгомжтой байдлаар нэрлэн заах нь ач холбогдолтой юм.

8.Хуулийн 27 дугаар зүйлийн 27.13-т “Төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг сонгуулийн төв байгууллагын шийдвэрийн дагуу намын төв байгууллагад олгох бөгөөд салбар болон бүтцийн нэгжид хуваарилах асуудлыг намын дүрмээр зохицуулна”, 41 дүгээр зүйлийн 41.3-т “Энэ хуулийн 41.1-д заасан арга хэмжээг авахад хүргэсэн алдаа, зөрчлийг намын орон нутгийн нэгж гаргасан тохиолдолд тухайн асуудлыг нам дүрмээр зохицуулна”, 42.4 “Энэ хуулийн 42.1-д заасан арга хэмжээг авахад хүргэсэн алдаа, зөрчлийг намын орон нутгийн салбар нэгж гаргах тохиолдолд зохицуулах заалтыг нам дүрэмдээ тусгана” гэж тус тус заасны дагуу намын санхүү, төсөв, аудитын дүгнэлтээр тогтоогдсон алдаа зөрчлийг арилгах талаар намын дүрмээр зайлшгүй зохицуулахаар байна. Эдгээр асуудлуудыг тус намын дүрэмд тодорхой зохицуулаагүй байна.

9.Намын дүрмийн 4.1.4-т “Их хурлын төлөөлөгчдийг сонгохдоо гишүүдийн оролцоог ханган, ил тод байдлыг сахиж, нууц санал хураалтаар шийдвэрлэнэ. Ингэхдээ жендэрийн тэгш байдлыг хангаж аль нэг хүйсийн эзлэх хувь 40 хувиас доошгүй байх шаардлагыг хангасан байна.”, 4.4-т “Бага хурлын төлөөлөгчдийг сонгохдоо гишүүдийн оролцоог ханган, ил тод байдлыг сахиж, нууц санал хураалтаар шийдвэрлэнэ. Ингэхдээ жендэрийн тэгш байдлыг хангаж аль нэг хүйсийн эзлэх хувь 40 хувиас доошгүй байх шаардлагыг хангасан байна.”, 4.6-д

“Удирдах зөвлөлийг бүрдүүлэхдээ гишүүдийн оролцоог ханган, ил тод байдлыг сахиж, нууц санал хураалтаар шийдвэрлэнэ. Ингэхдээ жендэрийн тэгш байдлыг хангаж аль нэг хүйсийн эзлэх хувь 40 хувиас доошгүй байх шаардлагыг хангасан байна.” 4.8-д “Хяналтын хорооны бүрэлдэхүүнийг сонгохдоо гишүүдийн оролцоог ханган, ил тод байдлыг сахиж, нууц санал хураалтаар шийдвэрлэнэ. Ингэхдээ жендэрийн тэгш байдлыг хангаж аль нэг хүйсийн эзлэх хувь 40 хувиас доошгүй байх шаардлагыг хангасан байна.” гэж тус тус заасан.

Хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т “Энэ хуулийн 16.1-д заасан байгууллагыг бүрдүүлэхдээ дараах шаардлагыг хангана.” 8.2.3-т “нэр дэвшүүлэхдээ аль нэг хүйсийн төлөөлөл 30 хувиас доошгүй байх” гэсэнтэй нийцэж байгаа боловч, мөн хуулийн 17 дугаар зүйлийн 17.7-д “Намын төлөөллийн төв байгууллага, гүйцэтгэх төв байгууллага болон хяналтын байгууллагын бүрэлдэхүүнд аль нэг хүйсийн төлөөлөл 40 хувиас доошгүй байна” гэсэнтэй зөрчилдөж байна. Тодруулбал, хуулиар намын удирдах байгууллагад нэр дэвшүүлэхэд аль нэг хүйсийн төлөөлөл 30 хувиас доошгүй байхаар, харин нэрлэн заасан удирдах байгууллагын бүрэлдэхүүнд аль нэг хүйсийн төлөөлөл 40 хувиас доошгүй байхаар тусгайлан заасан тул дүрмийн холбогдох зохицуулалт нь хуулийн уг шаардлагад нийцэх учиртай.

10.Намын дүрмийн дугаарлалт нь “3.5.1” гэсний дараа “3.4.2” гэж, “3.4.2” гэсний дараа “3.5” гэж, “5.4” гэсний дараа “5.4” гэж дугаарласан алдааг залруулах шаардлагатай.

Иймд дээрх үндэслэлүүдээр Монголын ногоон намын хүсэлтийг хангах үндэслэлгүй, нам өөрийн дүрэмд заасан журмын дагуу дахин хуралдаж, дээрх зөрчлүүдийг арилгасны үндсэн дээр Улс төрийн намын тухай хуульд нийцүүлэн намын дүрмийн өөрчлөлтийг шинэчлэн баталж, хуульд заасан хугацаанд Улсын дээд шүүхэд дахин хандах эрхтэй.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.8, 26 дугаар зүйлийн 26.1-д заасныг тус тус удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Улс төрийн намын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5-д заасныг баримтлан Монголын ногоон намын дүрмийн өөрчлөлтийг бүртгэхээс татгалзсугай.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ
ИЛТГЭГЧ ШҮҮГЧ

Д.ГАНЗОРИГ
Ч.ХОСБАЯР